



НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН  
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

**НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035  
Утас/Факс: (976-11) 32-71-99,  
<http://www.ulaanbaatar.mn>

2019. 11. 01 № 07/5200  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Санал ирүүлэх тухай**

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулан цахим хуудастаа [www.mojha.gov.mn/](http://www.mojha.gov.mn/) байршуулан санал авч байна.

Уг хуулийн төслийн зорилго нь хууль, төрийн зохих дээд шатны байгууллагын шийдвэрээр зохицуулаагүй, уг харилцааг зохицуулах захиргааны хэм хэмжээний акт батлах эрх хуулиар тусгайлан аль нэг байгууллагад олгогдоогүй боловч зайлшгүй зохицуулалт шаардлагатай орон нутагт тулгамдаж буй асуудлаар захиргааны хэм хэмжээний акт гаргах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэж байна.

Иймд хуулийн төсөлтэй танилцаж, хариуцсан чиг үүргийн хүрээнд зайлшгүй захиргааны хэм хэмжээний акт гаргах шаардлагатай, эсхүл нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор гаргасан журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй байгаа бол холбогдох хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал, үндэслэл, холбогдох судалгаа, танилцуулга, баримтын хамт 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



А.ДАВААЖАРГАЛ